



МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу, Засгийн газрын IV байр,  
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

"ДАРХАН ДУЛААНЫ СУЛЖЭЭ"  
ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
Б.АЛТАНЦЭЦЭГ ТАНАА

2014.04.30 № 01/42 ЧАТ-САТ/2014/197СМ/А

Зөрчил арилгуулах тухай

Төрийн Аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд "Дархан дулааны сүлжээ" ТӨХК-д 2013 онд эрсдлийн аудит хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- “Дарханы дулааны сүлжээ” ТӨХК-иас зарласан 2012 оны Б-002-02 тоот тендерт “Дарсан тех” ХХК шалгарч 2012 оны 05 дугаар сарын 01-ний өдөр 66.1 сая төгрөгөөр ОХУ-ын гарал үүсэл бүхий ган хаалтууд нийлүүлэхээр №30 тоот гэрээг байгуулсан боловч гүйцэтгэлээр БНХАУ-д үйлдвэрлэсэн ган хаалтуудыг нийлүүлсэн нь “гэрээний 1.2-т ... ОХУ-д үйлдвэрлэсэн ..., Хавсралт №01-д Гарал үүслийн улс ОХУ байх”-ыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12 “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх...”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1.1 “...алдаа зөрчлийг арилгуулахаар төрийн аудитын байгууллага холбогдох албан тушаалтанд албан шаардлага өгнө” гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ НЬ**:

Дээрх зөрчлийг арилган, албан шаардлагын биелэлтийг 2014 оны 6 дугаар сарын 30-ны дотор Үндэсний Аудитын газарт албан ёсоор хариу ирүүлэхийг “Дарханы дулааны сүлжээ” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Б.Алтанцэцэг, нягтлан бодогч Ч.Тогоо нарт хариуцуулсугай.

ЧАНАРЫН БАТАЛГААЖУУЛАЛТЫН  
АЛБАНЫ МЕНЕЖЕР



Г.НЯМДОРЖ